

Монголчуудын төрөлх өгөгдөл, унаган чанар

Сандуйжавын Одхүү, доктор (Ph.D), профессор

Отгонтэнгэр их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

odkhuu@otgontenger.edu.mn ; <https://orcid.org/0009-0002-3295-429>

Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-20

Published : 2024-12-20

Түлхүүр үгс

мэргэн ухаан,

аз жаргал,

баяр баясгалан,

төгс сайхан

Хураангуй: Монголчуудын үндэсний сэтгэлгээний шинж төрх, зан араншин нь бидний язгуур соёл, амьдралын хэв маяг, шашин шүтлэг гадныхтай холилдоогүй харьцангуй цэвэр, дангаараа байсан эрт дээр үед хоногшин тогтож, төлөвшин хөгжиж ирсэн онцлогтой. Монголчууд сүүлийн 3 зууны хугацаанд харь гүрний эрхшээлд, оюун санааны эрх чөлөөгөөр гачигдаж ирсэн учир улс төр, үзэл суртлын болон соёл шашны нөлөөнд автах, манжуулах, хятаджуулах, оросжуулах, баруунжуулах алсын зорилго, далд бодлогын туршилтын талбар болж ирсэн гашуун сургамж бий. Харийн бодлого, гаднын нөлөөний үр дүнд бидний монголчууд унаган шинж төрх, үндсэн зан, үндэсний онцлогоо ямар нэг байдлаар гэж, бүдгэрэн балартаж, “олдмол” маягийн зан чанартай болсон нь нууц биш, бас түүхийн үнэн юм.

Keywords

wisdom,

happiness,

joy,

native qualities

The native data and native qualities of Mongolians

Odkhuu Sanduijav (Ph.D), professor

Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

odkhuu@otgontenger.edu.mn;

<https://orcid.org/0009-0002-3295-4290>

© The Author(s), 2024



Abstract: Each country has different mindsets, images, behaviors, and internal facts that come from its existence, its active economy, its traditional lifestyle, its daily lifestyles, and its intrinsic facts. Many factors contribute to the disintegration and unification of Mongolians, including, without limitation, living conditions, income, language and culture, mentality, traditions and inheritance, habits, behaviors and characteristics, personalities, ways of life, appearance and body, image, mentality, attitudes and trends. All these characteristics attract both foreigners and researchers. We also bring together and globalize through various features. We will talk about several characteristics that separate, disintegrate and separate Mongolians from other countries.

I. Оршил

Монголчуудын үндэсний сэтгэлгээний шинж төрх, зан араншин нь бидний язгуурсоёл, амьдралын хэв маяг, шашин шүтлэг гадныхтай холилдоогүй

харьцангуй цэвэр, дангаараа байсан эрт дээр үед хоногшин тогтож, төлөвшин хөгжиж ирсэн онцлогтой. Монголчууд сүүлийн 3 зууны хугацаанд харь гүрний эрхшээлд, оюун

санааны эрх чөлөөгөөр гачигдаж ирсэн учир улс төр, үзэл суртлын болон соёл шашны нөлөөнд автах, манжжуулах, хятаджуулах, оросжуулах, баруунжуулах алсын зорилго, далд бодлогын туршилтын талбар болж ирсэн гашуун сургамж бий. Харийн бодлого, гаднын нөлөөний үр дүнд бидний монголчууд унаган шинж төрх, үндсэн зан, үндэсний онцлогоо ямар нэг байдлаар гэж, бүдгэрэн балартаж, “олдмол” маягийн зан чанартай болсон нь нууц биш, бас түүхийн үнэн юм.

Ард түмний үндэсний сэтгэлгээг авч үзэх онол, арга зүйн үндсийг үе үеийн эрдэмтэн судлаачид, сэтгэгчид, соён гэгээрүүлэгчид хөндөн тавьж, тал бүрээс нь тайлбарлахыг зорьсоор ирсэн байдаг. “Амьдралын зөв зам нь эхлэн алхахад хамгийн хэцүү, бартаат тэр зам байдаг” хэмээх алдарт үгийн эзэн Францын өвөрмөц сэтгэгч, алдарт зохиолч Франсуа Мориак¹: “үндэстэн бүхэнд төрөлхийн өвөрмөц шинж чанарууд байдаг” хэмээсэн нь үзэл баримтлалын шинжтэй гаргалгаа болсон гэж судлаачид үздэг, үнэлдэг.

Монгол судлаач, дипломатч, ОХУ-ын академич И.С.Майский: «**Монгол хүний оюун санааны хамгийн чухал шинж, сэтгэцийн үндэс нь назгай байдал мөн**» (Майский И.С. 1921) ^{2*} гэж монголчуудын зан төлөв, төрөлх араншингийн талаар илүү бодитой, сургамжтай, гашуун боловч үнэн хатуу үгээр илэрхийлсэн зарим \8 зүйлээр\ гаргалгааг бичиж үлдээсэнд эмзэглэх бус харин санаа авч эдгээр гэм зэм, сул

талаа даван туулахад анхаарууштай (Майский И.С. 2005, 387)

II. Судалгааны үр дүн

Харвардын Их сургуулийн профессор Ховард Гарднер “**Хүн өөрийн оюуны чадавх, сэтгэлгээний онцлог, аливаад хандах арга барилаа таньж мэдэн, хөгжүүлэх нь нэн чухлыг**” онцлоод “хүмүүс бид бие биеэсээ ялгаатай байдаг нь хүн болгоны оюун ухаан өөр өөр байдагтай холбоотой. Хэрэв бид үүнийгээ анзаардаг бол амьдралд гарч байгаа саад бэрхшээлийг давах нь хялбар байх сан” (Gardner H.E. 2000) хэмээж хүний оюун ухаан, сэтгэлгээний хэв шинж нь төрөлхийн онцлогтой болохыг судалж тогтоожээ. Улмаар энэ язгуур онцлог, унаган шинжээс шалтгаалан хүний авьяас билэг, ур чадвар улмаар ажлын явц, бүтээмж, үр дүн, амжилт бүтээл харилцан адилгүй байдагийг нотолсон байдаг.

Улс үндэстний түүх соёл, газар зүйн орчин, амьдрал ахуй, ард түмний зан заншил, өв уламжлал, хөгжлийн түвшин, хүн амын боловсролын түвшин өөр өөр байдаг нь бусдаас ялгаатай сэтгэлгээний хандлага, зан үйлийн хэвшмэл шинжтэй болгодог.

Оросын эрдэмтэн, сэтгэл судлаач И.Г.Дубов менталитетийг /унаган чанарыг-С.О./ тодорхой соёлд оршдог хүмүүсийн интеграль /нэгдсэн/ тодорхойлолт гэж үзээд энэ нь “ертөнцийн тухай тэдний ерөнхий төсөөллийг илэрхийлдэг,

¹ Франсуа Мориак (Francois Mauriac 1885-1970)-францын зохиолч, Францын академийн гишүүн, Нобелийн утга зохиолын салбарын шагналт (1952), XX зууны католик зохиолчдын нэгэн сүмбэр оргил. Нобелийн шагналыг “зохиол бүтээлдээ хүний амьдралын утга учрыг тод тусган харуулсан, оюун санааны гүн сэхээрэл, уран сайхны хүч чадлыг сод илэрхийлсний төлөө” хүртсэн хүн.

² * ЗСБНХУ-ын ШУА-ийн Дэд Ерөнхийлөгч, академич, Элчин сайд Майский Иван Михайлович (жинхэнэ овог нэр нь - Ян Ляховецкий) (1884 – 1975).

түүнд нөлөөлдөг өвөрмөц онцлогийг тусгадаг” (Dubov I.G. 1993) гэж үзсэн байр суурийг хүлээн зөвшөөрч болно.

Үндэстэн, ард түмэн бүр өөрийн өвөрмөц онцлогтой. Онцлог гэдэгт сайн нь ч, саар нь ч багтана. Ер нэг тийм нийтлэг зан араншин, амьдралын хандлага тод илэрч байдаг. Бидний «Монголчууд нийгэм соёлын хүн судлалын ангиллаар Дотоод Азид хамаардаг. Энэ ард түмэн 1. Нүүдэлчин, 2. Малчин, 3. Байгальтай ойр амьдардаг нийтлэг онцлогтой. Эндээс л монголчуудын сэтгэлгээний мөн чанар бүрэлдсэн» гэж МУИС-ийн багш, доктор Д.Бум-Очир бичсэн байдаг. Тэнгэр заяатай, тэнэгэр язгууртай, хөх толбот (Батсуурь Ж. 2008), байгалийн өгөгдөлтэй, оюуны онцгой чадвартай, ой тогтоолт сайтай гээд л хэт өргөмжлөн магтаж, өөрсдийгөө хорвоод байхгүй ховор ард түмэн мэт хөөрцөглөх нь төөрөгдөл болой. Магадгүй биеэ хэт магтах энэ эмгэг бидний өөдлөхгүй байхын нэг учир, учиг байж мэднэ. Даяаршлын нөхцөлд бид онцгойроод байх утгагүй, ард түмэн бүрт байдаг л өгөгдлүүд. Монголчууд бие махбодын хувьд бусад үндэстнээс огтоос ялгаагүй гэдэг нь шинжлэх ухааны судалгаагаар нэгэнт тодорхой болсон, нотлогдсон зүйл билээ.

Монгол хүний менталитетыг нэлээд эртний үеэс улируулан онол, практикийн үүднээс судалсан нь Философийн шинжлэх ухааны доктор Н.Хавх болно. Тэр менталитет гэдэг үгийг “унаган төрх”, “унаган чанар” гэсэн монгол нэр томъёогоор дүйлгэн түүхийн эх сурвалж, баримт судалгаанд тулгуурлан нэлээд ултай тодорхойлсон байна.

Янз бүрийн улс орон, ард түмэн, үндэстэн угсаатан, нийгмийн том

бүлгийн зан араншин, амин чанар, өвөрмөц онцлогийг харьцуулан авч үзэх нь арга зүйн чухал шаардлага мөн. Аливаа ард түмний менталитетэд (Ганхуяг Д. 2012) улс орных нь биологийн, цаг агаарын, соёлын, угсаатны болон нийгмийн хүчин зүйлүүд нөлөө үзүүлдэг болохыг эрдэмтэн мэргэжилтнүүд судлан тогтоосон байдаг. Чухамхүү үүний үндсэн дээр ямар нэг тодорхой нөхцөлд, тогтсон арга, хэлбэрээр, хэв маягаар бодох, үйлдэхэд, ажиллаж амьдрахад хүн бүрийг хүргэдэг, далд дотоод түлхэц хүч үүсч, үйлчилдэг.

Суурин соёлд цаг хугацаа чухал байдаг бол нүүдэлч соёлд орон зай эрхэм байжээ. Нүүдэлч иргэншлийн хүмүүс орон зайг чухалчилж ирсэн нь цаг хугацааг мяралзан үзэгдэж өнгөрөх голын урсгал мэт хүн төрөлхтний төлөө үргэлжид сайхнаар гүйлгэхийн тулд дэлхий ертөнц өөрөө эрүүл саруул байх ёстой гэж сэтгэж амьдарсных юм. Орон зай гэдэг асар том ухагдахуун. Сэтгэлийн орон зай, зөн билгийн орон зай, хувийн орон зай, харилцааны орон зай гэхчлэн олон орон зай байхын хамт бодит ертөнцийн хэмжээсийг ч орон зай гэж ойлгож болно. Байгаль дэлхий орон зайн бүрэн эрхэт оршихуй билээ.

Хүн төрөлхтөн байгаль дэлхийтэйгээ хамт үгүй болчихвол цаг хугацаа урссаар байх уу, уудам тал, халил хясаанд тулж гэнэт таг зогсох уу, үнэндээ юуны ялгаа байх вэ дээ. Цаг хугацааны гадна орших юу ч байхгүй гэдгийг нүүдэлч ард түмэн сайн мэднэ. Монголчууд цаг улирлын ааль, ааш, өөрчлөлт, хувирлыг мэдэрч, цэцэг ногоо гандаж, дэлгэрэхийг харж, модод ногоорч, уулс бууралтахыг үзэж өссөн учраас бүх зүйл нэгэнт хэвэндээ байдаггүйг мэддэг, байгалиас

суралцсан байдаг. Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй хэмээнэ.

Уудам орон зай, байгалийн хүнд нөхцөл, амьдралын хэв маяг, туулахын эцэсгүй хол зам, санамсаргүй өөрчлөлт гэнэтийн тохиол учрал бүхэн монгол хүнд өөрөө л сурч мэдэхгүй бол амьдрахын аргагүй тийм нөхцлийг үүсгэсэн юм. Мэдэхгүй чадахгүй зүйлээ очоод асуучих суурин иргэншлийнх шиг “юм мэддэг” эрдэм номтой хүн ховор, суугаад үзчих номын сан байсангүй. Хамгийн ойрын итгэлт багш нь байгаль эх.

Миний бие “Монгол менталитет” (Одхүү С. 2019, 2022, 166) номондоо бидний давуу, сул тал, илүү дутуу шинж, зарим өвөрмөц онцлогийг тодруулан авч үзсэн болно. Муухай монгол хүний төрөлх шинжийг манай эрдэмтэн, судлаачид^{3*} (Батчулуун Б. 2021, 191), (Владимир И. 2013) ажиглалт, судалгаад үндэслэн тодруулж тодорхойлсон нь бий^{4*} (Батмөнх С. 1991, 96), (Батболд Ж. 2018, 184)

II. Үндсэн хэлэлцүүлэг

Буурал түүхийн нугачаа, урт хөгжлийн улбаанд монголчууд биднийг монголоороо үлдэхэд нөлөөлсөн, хүргэсэн давтагдашгүй онцлог чанар, сэтгэлгээний өвөрмөц шинж төрх, араншин чухам юунд оршиж байдаг

нь бидний анхаарал, сонирхлыг татдаг юм. Монгол судлалын эх сурвалж, түүх шаштир, ном бүтээлийг сонирхон сөхөж үзвээс монгол үндэстний сэтгэлгээний салшгүй шинж төрх, араншин монголчуудын түүхийн эрт үед л байсан, түүхэн цаг хугацааны турш, түүхэн орон зайн янз бүрийн орчинд өвөрмөц онцлогтойгоор уламжлагдан хадгалагдсаар өнөө үеийг хүрч иржээ. Хүн төрөлхтний хөгжил дэвшлийн нийтлэг зүй тогтол, цаг үеийн шаардлага онцлогтой өмнөх үеийнхээ бүх л үнэ цэнэтэй бүхнийг танин мэдэж, ойлгон ухаарч, өвлөн авч, сэргээн мандуулж, боловсронгуй болгон баяжуулж үзсэний үндсэн дээр цааш хөгжих шинэ боломж, гарцыг олж харж, өмнө байгаагүй чухал байр суурийг эзлэж, таарч тохирсон үүргийг гүйцэтгэх болно.

Унаган төрх хэмээх менталитет бол тодорхой бие хүн, нийгмийн бүлэг, үндэстэнд хэвшин тогтсон оюун санааны дадал зуршил, ахуй араншингийн чиг хандлагын нийлбэр цогц, сэтгэлгээний хэв маяг мөн. Менталитет нь хүний үйл ажиллагаа, амьдрал ахуй, зам төлөвийн бүхий л хүрээнд цогц шинжтэй байдаг.

Бидний монголчууд ертөнцийн одод эрхэсийн тохиол, газар дэлхийн хувирал, байгалийн олон янз өөрчлөлтийг хар багаасаа харж өссөн, 4 улирлын өөрчлөмтгий орчин

^{3*} Б.Батчулуун 22 сэдвийн хүрээнд монголчууд “бид ямар болчихоод байна вэ?” гэдэг асуудал дэвшүүлэн, баримт судалгаанд үндэслэн, хагуухан үгээр чимхээд авсан нь бидэндээ тус болохоор анхааруулга болсон гэлтэй. Ер бид чинь өөрсдийнхээ гэмийг мэдэхээ байж, харахаа больглоо дасан зохицсон нь үнэний хувьтай шүү. Эдгээр судлаачдын бүтээлд эмзэглэн дургүйцэх биш, юу хэлээд байгааг ойлгон ухаарч, үнэхээр бидний амьдрал, үйл ажиллагаанд байдаг муухай араншин, муу шинж, сул талуудаасаа бага ч гэсэн ангижирч, өөрсдийгөө өөрчлөхөд нэмэр болмоор сургамжтай бүтээлүүд болсон гэж үзэж байна.

^{4*} Биднийг муухай харагдуулдаг, өөдгүй болгодог 28 сул талыг ерийн ухамсын түвшинд ойлгогдохоор энгийн, ойлгомжтой бичсэн нь хэн боловч санаж, сэрэх сургамжтай бүтээл болсон юм. Ж.Батболд-Нүцгэн үнэн монголын аварна уриатай энэ номонд зохиогчийн 31 бодрол буюу энэ тооны гэм зэмийн тухай өгүүллэ. Өөрсдөө л анзаардаггүй болохоос өдөр тутам л бидний амьдал илэрдэг ааш араншин, гэм зэмийг дурайтал л харуулсан байгаа юм.

нөхцөлдөө тааруулж хурдан түргэн, уян хатан сэтгэдэг, дасан зохицох чадвар сайтай хүмүүс. Хуучны өв уламжлалаа дагаж ирсэн ард түмэн хүчтэй. Холын түүхтэй ард түмэн алсын ирээдүйтэй. Бидний монголчууд дэлхийд түүхээрээ багагүй танигдсан. Гол нь нүүдэлчин амьдралын хэв маягаараа ялгарах учиртай. Язгуур сэтгэлгээ, ёс зүй, зан заншил, хэвшил зуршил чухал.

Манай нутгаар янз бүрийн цаг үед аялан зорчсон, бидний өвөг дээдэстэй уулзаж учирч явсан гадны хүмүүс, харийнхан бидний монголчуудыг (Одхүү С. 2022, 176) зөвхөн өөрийн тогтсон ухаан, хэвшмэл хандлага, явуулын хүний өнгөц ажиглалтаар, хоноцын сэтгэлгээгээр дутуу ойлгох, буруу дүгнэхийг оролдсон байдаг (Одхүү С. 2022, 162). Ингэхлээр бидний талаарх тэдний мэдлэг харагдах байдал, үзэгдлийн өнгөц түвшинд, алдаа мадагтай байх нь бий. Ингэхлээр тэдний ажиглалт, тэмдэглэл, дурсамжийг магад үнэн гэж үзэх аргагүй.

Нүүдэлчид суурин иргэдээс яагаад илүү хүчтэй байсан талаар энгийнээр тайлбарлавал нүүдэлчид бол байгальтай ойр байж, байгалийн орчинд дасан зохицож, шүтэн барилдаж амьдарч, аж төрдөг. Тэгвэл хот суурингийн иргэд бол зохиомол орчинд гаршуулсан тэжээвэр шинжтэй хүмүүс байдаг. Зэрлэгээрээ байгальд байгаа амьтад тэжээвэр амьтаас амьдралын тэсвэр хатуужил хамаагүй илүү байдаг нь судалгаагаар нотлогдсон зүйл. Бидний монголчууд (Эрдэнэ С. 1989) байгальд ойр байдаг, байгальтай шүтэлцэж амьдардагийн хувьд байгалиас маш ихийг сурсан, ертөнцийн бүх юмс, үзэгдэл

хоорондоо салшгүй холбоотой, шүтэн барилдлагатай гэдгийг мэдэрсэн, чухалчилдаг хүмүүс. Монголын уудам тал нутагт хүн төрөлхтөн сая шахам жил амьдрахдаа хэзээ ч, хэн ч амьдарч байгаагүй мэт эзгүй зэлүүд нутаг, эгэлгүй онгон байгалийг л өвлөж үлдээсэн нь гайхалтай. Монголчууд эдийн соёлоос оюуны соёлыг илүү эрхэмлэж ирсэн ухаант ард түмэн. Эртний хаадууд бидэнд орд харш байтугай онгон шарилаа ч үлдээгээгүй, аливааг чанд нууцалдаг нь бас нэг онцлог (Түдэв Л. 2013).

Монголчууд цаг хугацаанд биш цаг агаарт захирагддаг уламжлал бий. Цаг агаар өөрчлөгдөх, салхи шуурга дэгдэх, цас бороо орох, халуун хүйтэн болох зэргийг ямар ч техник хэрэгсэл, багаж төхөөрөмжгүйгээр тэнгэрээ уншиж, газраа шинжиж, мал амьтны зан араншин, байр байдлыг хараад л хэлдэг чадвартай, байгалийн үзэгдлийн элдэв дохио, үүлний нүүдэл, салхины чиг, араатан жигүүргэн, хорхой шавьжны явдал хөдөлгөөн, үйлдлээр цаг агаарын өөрчлөлтийг мэддэг (Одхүү С. 2020, 18-22). Тэнгэр унших мэдрэмж, ухаан гайхалтай.

Сэтгэл судлалын үндэсний төв монголчуудын сэтгэлгээний онцлог хэв шинж болон тэдэнд тулгамдаад буй сэтгэл зүйн асуудлыг тодруулах өргөн хэмжээний судалгааг хийж, үр дүнг нь танилцуулсан байдаг. Судалгаанаас сонирхол татсан нэг дүгнэлт нь **“монголчууд амьдралын тодорхой зорилгогүй, чухам юу хийж чадахаа тодорхойлж чаддаггүй”**, төлөвлөлт байдаггүй, урсгалаараа гэлдэрч явдаг болох нь илэрсэн ажээ. Эндээс бидний сонголчууд өөрсдийгөө сайн судалж таниагүй, хувь хүн өөрийгөө ойлгож, олоогүй байдал тодорхой байна. Бас 10

шатлалтай үнэлгээгээр ихэнхи монгол хүн өөрийгөө 8 эсвэл 9 гэж үнэлдэг аж, энэ нь эго өндөртэй, би гэх хандлага түлхүү илэрдэгийн бодит баримт юм.

Орчин үеийн залуус бие дааж амьдрах тал нь сул болсныг судалгаанаас харж болно. Ялангуяа шийдвэр гаргах үед дээрх эго өндөр байдал эсрэгээр эргэж үнэлэмж нь 2-3 хооронд эргэлддэг нь анхаарал татаж байна. Энэ нь аливаад оролцоо, идэвхи сул байгаагийн илрэл юм. “Төрийн төлөө хулгана боож үхэх” гэдэг уламжлалт идэвхигүй хандлага амь бөхтэй байсаар байгааг харуулж байна.

Хуримтлагдсан, тулгамдсан асуудлыг олж хараад уг сурвалж, учир шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлон, шийдэх боломж, арга замыг эрэлхийлэхийн оронд харсан сонссон бүхнээ муулдаг бидний өөдгүй зан үүнийг ямар ч баримт нотолгоо, шинжилгээ оношлоогүйгээр батлаад өгнө. Үүн дээр монгол хүний савлаж, туйлширдаг өрөөсгөл араншинг нэмчихээр өнөөгийн Монголын амьдрал дан саарал бараан өнгөөр зурагдаад явчихна. Эндээс бүх нийтийн дургүйцэл бухимдал, нийгмийн сэтгэл зүйн тавгүй уур амьсгал үүсдэг болохыг эрдэмтэн судлаачид анхааруулдаг.

Хавтгай халамжийн ноцтой үр дагавар нь Монголчууд амар хялбараар л амьдрах гэдэг гэнэн мөрөөдөлтэй болсон нь харамсалтай. Хүнийг өөрийг нь чадваржуулж хөгжүүлсэн хөдөлмөр үеийн үед л эрхэм үнэт зүйл байсан. Мал сүрэг, байгаль дэлхийгээс бараг бэлнээр амь

зуулгаа залгуулж ирсэн монголчууд хөдөлмөрийн үнэ цэн, үр шим, амт ач холбогдлыг сайн мэддэггүй, мэдэрдэггүй нь үнэний хувьтай, хүлээн зөвшөөрвөл зохино. Хөлс, хүчээр бий болдог капиталист үйлдвэрлэлийн аргыг туулаагүй нь олон зүйл дээр харагддаг. Тэгшитгэх бодлого, тэтгэх хандлагын улмаас бэлэнчлэх сэтгэлгээ, тэжээвэр аргад дэндүү дасгасан нь бас нэрмээс болдог. Монгол Улсад 70 гаруй халамжид 2 сая илүү хүн хамрагддаг тухай статистикийн баримт үүнийг гэрчилнэ (Батмэнд Р. 2009, 424).

Зах зээлийн харилцаанд орсноос хойш хөдөлмөрийнагуулга өөрчлөгдөн, түүнд хандах байдал шинэчлэгдэн хүн бүр хөдлөхгүй, хөдөлмөрлөхгүй бол болохгүй гэдгийг ойлгон мэдэрч, амьдрал дээшлэхгүй гэдэг үзэл, үйлдэл хэвшиж тогтон дор бүрнээ л боломж, бололцоогоо эрэлхийлж, толгой гараа ажиллуулж эхэлсэн нь сайшаалтай.

Өнгөрсөн зуунд учирсан, тохиолдсон хүндрэл бэрхшээлийн нэг бол нүүдэлч-малчдыг орчин үеийн иргэншсэн хүн, ажилчин, тариаланч, сэхээтэн болгож хувиргах амаргүй үйл явц байсан. Эзгүй хээр, уудам нутагт ганц гэрээр, хот айлаар голдуу аж төрж ирсэн нүүдэлчдийг суурьшуулах, малчдын хөдөлмөрийг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, хамтын хүчний давуу талыг ойлгуулахад ч бэрхшээл тулгарч, дасаж өгөхгүй байсан. Энэ тухайд уран зохиол, тайз дэлгэцийн олон бүтээл гарсан даа.

Монголчууд суурин амьдралд шилжээд ердөө 2-3 дахь үе дээрээ л явж байгаа^{5*} болохоор нүүдэлч сэтгэхүй,

^{5*} Түүхийн эх сурвалжийн мэдээгээр 1919-20 онд нийслэл хүрээнд 100 мянга орчим хүн байсны 3 мянга орчим нь оросууд, 38 мянга нь монголчууд бусад нь хятадууд байсан. Эдүгээ нийслэл хотдоо 1.7 сая хүн амьдардаг болсон.

аажуу тайван хандлага зарим хүний үг хэл, үйл хөдлөлд үе үе илэрдэг. Төвлөрөлд суурилсан амьдралын хөдөлгөөнт хэвшилд нийцэхгүй байдал, их хотын соёлд дасаж дадаагүй хандлага, бүр нус цэрээ хэнэг ч үгүй палхийтэл хаях, замын хөдөлгөөнийг үл тоож хашлага давж, газар товчлох байдлаар явах, гэрлэн дохионы улаан гэрлээр зүтгэх гэнэ.

«Human Dignity» хэмээх ойлголтыг барууны философчид 15-р зууны үеэс ярьж эхэлсэн. Харин Монголд энэ ойлголт өнөөдрийг хүртэл олигтой яригдсангүй Монгол хүн өөрийгөө ойлгох, танин мэдэх гэж хичээдэггүй тал байх шиг санагддаг. Монголын нийгэм бас иргэнээ хүндэлж, үнэлдэггүй. Монгол хүнд дигнити бүдэг байна уу. Монголд ярьдаггүй биш, хүн дээд төрөлтөн гэж үздэг шашин уламжлал бүр эртнээс байна. Хүн болж төрөх нь зүүн дээр тогтох будааны адил, тиймээс эрдэнэт хүмүүн гэж бичиж ярьж ирсэн (Балхаажав Ц. 1992, 146). Цааш нь хөгжүүлэх, орчин үетэй нийлүүлэх боломж нь гараагүй байх талтай.

Монгол хүний нэг өвөрмөц онцлог бол аливааг бүхэлд нь, бүтнээр нь, бусад юмс, үзэгдлийн холбоо хамааралд, шүтэлцээнд нь авч үзэх, ерөнхийлөн харах чадвар, панаромный сэтгэлгээ (Юндэндорж А. 2004). Барууныхан нэгжээс Ерөнхий рүү сэтгэж, үйлддэг бол дорныхон, тодруулбал монголчууд Ерөнхийгөөс нэгж рүү ухаж гаргалгаа хийдэг Уул хангай, тал хээр, адуу мал хайж, хонь хариулж явахдаа бүгдийг хараалан бүртгэх, мэдрэхээс гадна тэнгэрийн байдлыг гоц шинжинэ.

Монголчууд бол Дорнын ч биш, Өрнийн ч биш, геополитикийн тухайд

гайхалтай байршилтай, дэлхийн хоёр супер их гүрний дунд оршдог. Үзэл баримтлалын хувьд либерал ч биш, консерватив ч биш, тогтсон итгэл үнэмшил бүдэг, туйлширч савладаг араншинтай. Энэ холбиромтгой шинжийг хүн амын бүх давхарга, амьдралын бүх хүрээнд ажиглагддаг талцал, хуваагдлаас мэдэрч болно.

Бид өөрсдийгөө таних, ойлгох, мэдэх, түүндээ тулгуурлан хөгжих цаг болсон. Бас гадагш нь зөв таниулах, сайн сурталчлах шаардлага ч бий. Энэ нь дотроо ижилсэх, гадагшаа ялгарах шаардлага, хандлагатай холбоотой.

IV. Дүгнэлт

Нүүдэлчин удамт монголчууд цаг хугацааны үнэлэмжээс орон зайн баримжааг илүү чухалчилж ирсэн уламжлал, хандлага бий. Орон зайн мэдрэмж гайхалтай. Түнэр харанхуйд эзгүй хээр итгэлт морио унаад зүг чигээ одоод, төөрч будилалгүй, зорьсон газраа саадгүй хүрч чаддаг. Дөрвөн улирлын ааш араншин, өнгө аягт тохируулан газар нутгаа шилж сонгон нүүдэллэж, цаг агаарын ямар ч нөхцөлд мал сүргээ адуулан хариулдаг онцгой чадварыг орчин үеийн нөхцөлд бүтээчээр ашиглаж сурах цаг болжээ.

Бидний дасан зохицох хосгүй чадвар, гайхалтай тэсвэр тэвчээр, оюуны чадамж сайн, ясны төрхөмсүү болон шударга ёсыг чухалчлах уламжлалт давуу талуудыг хуулийг эрхэмлэн дээдлэх зарчимтай холбож, орчин үеийн стандарт мөрддөг болгож чадвал гайхамшигийг бүрдүүлж, өөдлөх дэвжихийн замд гарч болох юм.

Өнгөрсөн үеэс мах, цусанд шингэсэн, олигтой салж өгөхгүй байгаа залхуурал, цаг баримталдаггүй назгай байдал, гэм зэм, бидний ааш

араншин, зан үйл, ажил амьдралд илэрдэг соёлгүй, бүдүүлэг байдал, нэрэлхүү хэнэггүй зан, агаархуу бялдууч араншин, ойлгомжгүй тодорхойгүй байр суурь, хандлагыг даван туулж, өөрчлөх нь нь урагшлах хөдөлгөөн, хөгжил дэвшилд тустай байх болно.

Монгол хүнд гэрээ хэлцлийн хариуцлага, мэдрэмж сайн төлөвшөөгүй, гүйцэтгэлийн сахилга

Ашигласан материал

- Майский И.С. 1921. *Современная Монголия: Отчет Монгольской экспедиции, снаряженной*. Иркутск: Иркутской конторой Всероссийского Союза потребительных Товариществ «Центросоюз».
- Gardner Н.Е. 2000. *Intelligence reframed: Multiple intelligences for the 21st century*. Hachette .
- Dubov I.G. 1993. *Mentality phenomenon: a psychological analysis. Questions of psychology*. Moscow.
- Батсуурь Ж. 2008. “Хөх толбот монгол хүний бусдаас ялгарах чанар.”
- Ганхуяг Д., Монгол менталитет. 2012. 06 13. <http://ganaa.mn>.
- Одхүү С. 2019, 2022. *Монгол менталитет*. Улаанбаатар: ОТИС, “Соёмбо принтинг” ХХК.
- Батчулуун Б. 2021. *Монголчуудын олиггүй аранингаас*. Улаанбаатар.
- Владимир И. 2013. “Ертөнцийг үзэхүйг төлөвшүүлэхэд менталитетийн гүйцэтгэх үүрэг” докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар.
- Батмөнх С. 1991. “*Муухай*” монгол хүн 1991, -96т. Улаанбаатар.

бат сул, ам ажлын нэгдэл алдагддаг нь үнэний хувьтай. Энэ бол задгай, чөлөөтэй аж төрдөг нүүдэлчдээс өвлөгдсөн нэг гэм согог мөн. Дэлхий хавтгай болж буй даяаршлын өнөөгийн нийгэмд сул талаа даван туулж, давуу тал болгон хувиргах, харилцан ойлголцож хамтарч ажиллах чадварт суралцахаас өөр арга, зам байхгүй.

- Батболд Ж. 2018. *Муухай монгол хүн*. Улаанбаатар.
- Одхүү С. 2022. *Монголчууд: өгөгдөл, амин чанар, бусдын нүдээр. Герменевтик шинжлэлээ*. Улаанбаатар.
- Одхүү С. 2022. *Бидний монголчууд. Гадаадынхны нүдээр Герменевтик шинжилгээ* . Vol. Гуравдугаар дэвтэр . Улаанбаатар.
- Эрдэнэ С. 1989. “Бидний араншин” Улаанбаатар: “Хөдөлмөр” сонин, 01 03.
- Түдэв Л. 2013. “Монгол хүний давтагдашгүй таних гэмдгүүд.” Улаанбаатар: “Дал” сонин.
- Одхүү С. 2020. *Монгол малчны менталитет*. Улаанбаатар.
- Батмэнд Р. 2009. *Монголын хөгжлийн философи: Улс төрийн эдийн засгийн ухаан хамаарах нь* . Улаанбаатар.
- Балхаажав Ц. 1992. *Хүний хөгжлийн онол арга зүйн үндэслэл. Судалгаа, ажиглалт, бясалгал, дүгнэлт*. Улаанбаатар.
- Юндэндорж А. 2004. “Монголчуудын менталитетийн онцлог” “*Менталитет*” сэтгүүл. (МУБИС-ийн Түүх, нийгмийн ухааны сургууль) (1).
- Майский И.С. 2005. *Орчин үеийн монгол: автономит Монгол XX зууны гараан дээр*. орч. Отхон Ц. Улаанбаатар: “Адмон принт” ХХК.